



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

┌ Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.2-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн зарим зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам” /цаашид “журам” гэх/-д дор дурдсан 6.5 дугаар зүйлийг нэмсүгэй:

1/ “6.5. Үнэт цаасны мөнгөн төлбөрийн нэгдсэн данс нээх болон гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох.

6.5.1 Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь үнэт цаасны төлбөрийн данс нээх болон гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг Хорооны зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

6.5.2 Энэхүү журмын 6.5.1.-д заасан үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл хүсч буй зохицуулалттай этгээд нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

6.5.2.1 300.0 сая төгрөгөөс доошгүй хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх;

6.5.2.2. Үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн програмтай байх ба тус програм нь гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын болон кастодиан банкны системд нийцсэн, тухайн улсын хадгаламжийн байгууллагын дүрэм, журамд нийцүүлэн харилцагчийн хөрөнгийн бүртгэлийг хөтөлдөг байх;

6.5.2.3. Энэхүү журмын 6.5.2.2.-д заасан програм нь харилцагч өөрийн данс дахь хөрөнгийн талаарх мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр авах боломжоор хангасан байх;

6.5.2.4. Харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлан харилцагч тус бүрээр тусгайлан, нэр төрлөөр нь балансын гадуур дэлгэрэнгүй бүртгэж байх;/Харилцагчийн гадаад улсын үнэт цаасны зах зээлээс үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгө, худалдан авсан үнэт цаас, түүнтэй холбоотой орлогын тайлангийн тодруулгын “балансын гадуурх бүртгэлийн тодруулга” хэсэгт тусгана./

6.5.2.5. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах брокерийн үйл ажиллагаа эрхлэх тухай дотоод журмыг компанийн эрх бүхий этгээдээр батлуулсан байх;

6.5.3. Үнэт цаасны төлбөрийн нэгдсэн данс нээх болон гадаад арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн зохицуулалттай этгээд нь энэхүү журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягт СЗХ03002-ын дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралт (Ё)-д заасан баримт бичгийг хавсаргаж, Хороонд хэвлэмэл, цахимаар ирүүлнэ.

6.5.4. Үнэт цаасны нэгдсэн данс нээх болон гадаад арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авах, бүртгүүлэх өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж холбогдох хууль, журмаар тогтоосон шаардлагыг хангаж байна гэж үзвэл ажлын 20 хоногийн дотор Хорооны дарга шийдвэрлэнэ.”

2/ Журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягт СЗХ03002-ын 5 дугаар мөрний “зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирлыг томилох, өөрчлөх” гэсний дараа “үнэт цаасны нэгдсэн данс нээх болон гадаад арилжааны үйл ажиллагаа эрхлэх” гэж нэмэх.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Хорооны 2014 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам”-ын 9¹ дүгээр зүйлийг хүчингүй болгосугай.

3. Журамд холбогдох өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/, Бүртгэл зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
ДЭД ДАРГА ЭБАТБОЛД

